



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 14

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арвангурвдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу татан төвлөрүүлсэн Боловсрол, шинжлэх ухааны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 23,000,000 /хорин гурван сая/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 79-41 ДУА улсын дугаартай УАЗ фургон маркийн автомашиныг Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгийн дансанд, Дэлгэрхангай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 16,333,333.37 /арван зургаан сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг гучин долоон мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй 12,794,444.51 /арван хоёр сая долоон зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун дөчин дөрвөн төгрөг тавин нэгэн мөнгө/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 00-79 ДУА улсын дугаартай TOYOTA Land Cruiser маркийн автомашиныг Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгийн дансанд тус тус балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Адъяасүрэн), Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Мөнх-Оргил) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Шилжүүлэх хөрөнгийг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



